



Коронавирус-19 (Covid-19)-ээр халдварласан хүмүүс болон тэдний ар гэр болон ойр дотныхонд өгөх Гэртээ Тусгаарлах болон Хорио Цээрийн Зааварчилгаа

- 1) Хэрвээ эмчийн албан ёсны онош эсвэл лабораторийн шинжилгээний дүгнэлтээр COVID-19-ийн халдвартай нь тогтоогдсон бол <http://www.acphd.org/2019-ncov/resources/quarantine-and-isolation> -д зааснаар та Эрүүл Мэндийн Ажилтны тусгаарлагдах тушаалыг дагах ёстой.
- 2) Хэрвээ COVID-19-ийн халдвар авсан нь тогтоогдсон хүний гэр бүл, ойр дотнын хүн бол та <http://www.acphd.org/2019-ncov/resources/quarantine-and-isolation>, зааснаар хорио цээрийн дэглэм сахих ёстой.
- 3) Хэрвээ та шинжилгээнийхээ хариуг хүлээж байвал хариугаа иртэл тусгаарлах зааварчилгааг дагах хэрэгтэй. Хэрвээ шинжилгээний чинь хариу сөрөг гарвал цаашид ямар нэг арга хэмжээ авах шаардлагагүй бөгөөд энэхүү зааварчилгаа танд хамаарахгүй болно.

Гэртээ тусгаарлах зааварчилгаа

Хэрвээ та COVID-19-ийн халдвар авсан хэмээн оношлогдсон эсвэл шинжилгээнийхээ хариуг хүлээж байгаа бол халдвар тараахгүйн тулд Гэртээ Тусгаарлах эдгээр зааварчилгааг дагах ёстой.

Эдгэртлээ гэртээ байх

- COVID-19-ийн халдвар авсан ихэнх хүмүүсийн биеийн байдал ноцтой бус байдаг тул гэртээ зөв дэглэм сахивал, заавал эмнэлэгт хандахгүйгээр эдгэрэх боломжтой. Хэрвээ та 65 болон түүнээс дээш настай, жирэмсэн эсвэл зүрхний өвчлөл, астма, уушгины өвчин, чихрийн шижин, бөөрний өвчин болон дархлаа муутай бол эрсдэлд орж болох бөгөөд өвчин хүндрэх магадлалтай.
- Ажил, сургуульдаа явж, олон нийтийн газар очихгүй байх ёстой.
- Өвдснөөсөө хойш 10-оош доошгүй хоног, эдгэрснээсээ хойш 1-аас доошгүй хоног гэрээсээ бүү гар. Эдгэнэ гэдэг нь 24 цагийн дотор халуун бууруулах эм (жиш, Tylenol®) уухгүй байхад халуурахгүй байх ба. and амьсгалын замын өвчний шинж тэмдэг (тухайлбал ханиах, амьсгал давчдах г.м) сайжирсан байх ёстой.
- Хэрвээ та шинж тэмдэггүй ч COVID-19-тэй бол шинжилгээ гарсны дараа хамгийн багадаа 10 хоног гэрээс гарахгүй байх ёстой. Гэрт чинь байгаа хүмүүс, хань нөхөр болон асран халамжлагчид зэрэг хүмүүс “ойрын хавьтал”-д тооцогдох бөгөөд Хорио Цээрийн зааварчилгааг дагах ёстой. Үүнд шинж тэмдэг үзэгдэж эхэлснээс хойш, өөрийгөө тусгаарлахаас чинь өмнө 48 цагийн дотор тантай харьцсан хүмүүс орно. Иймээс энэхүү мэдэллийг тэдэнтэй бас хуваалцана уу.

Бусдаас өөрийгөө тусгаарлаж чадахгүй бол яах вэ?

- Тантай харьцаж байгаа хүн бүхэн, уулзсан өдрөөсөө хойш 15 хоногийн хугацаанд эсвэл таныг тусгаарлалтаас гарсан өдрөөс хойш хорио цээрийн дэглэм сахих хэрэгтэй болно.

Хорио цээрийн зааварчилгаа

Хэрвээ та COVID-19-ийн халдвартай нь оношлогдсон хүнтэй нэг гэрт амьдардаг эсвэл ойр харилцсан (Өөрийгөө тусгаарлах хүртлээ халдварын ямар нэг шинж тэмдэг илэрснээс өмнөх 48 цагийн дотор) бол хорио цээрийн дэглэм сахих ёстой. Шинж тэмдэг илэртлээ 2-14 хоног болох магадлалтай тул 14 хоног болтол халдвар авсан эсэхээ мэдэх боломжгүй юм. Бусдад халдвар тараахаас сэргийлэхийн тулд энэ хугацаанд гэртээ байж, эрүүл мэндээ хянах нь туйлын чухал юм.

Ямар нэг шинж тэмдэг илрэхийг ажиглан гэртээ бай

- COVID-19-өөр халдварласан хүнтэй ойр харилцсан үеэс хойш 15 хоногийг тоолсноор таны хорионы цээрийн дэглэм дуусах болно. Хэрвээ тухайн этгээдтэй та ойр харилцсаар байвал таны хорио цээрийн хугацаа дахин эхлэх болно.
 - Ойр харилцах гэдэг нь та COVID-19-ийн халдвар авсан хүнтэй 200 фийт зайд 15-аас илүү минут байсан, биеийнх нь шингэн болон бусад төрлийн ялгадаст тусгай зааварчилгааг дагалгүйгээр хүрсэн зэргийг хэлнэ.
 - Хэрвээ ойрын харилцаанаас зайлсхийх боломжгүй бол та COVID-19-тэй хүний тусгаарлалт дуусснаас хойш 15 хоногийн хугацаанд хорионд байх хэрэгтэй болно. Энэ нь хамгийн багадаа 24 хоног болно.

Хэрвээ танд шинж тэмдэг илэрвэл яах вэ?

- Хэрвээ танд COVID-19-ийн шинж тэмдэг илэрвэл, гэртээ тусгаарлах зааварчилгааг дагах хэрэгтэй
- Шинж тэмдгийг сайтар ажиглаж, хэрвээ шинж тэмдэг хурц болж ирвэл эмнэлгийн тусламж хай. COVID-19 нь бусад амьсгалын замын өвчинтэй адил их аюултай бус учраас зөвхөн халдвар авсан эсэхээ мэдэхийн тулд шинжилгээ хийлгэх шаардлагагүй. Гэртээ дэглэм сахихад эдгэнэ.

Гэрийн тусгаарлалт болон хорио цээрийн дэглэм сахих хүмүүст хамаарах мэдээлэл болон хязгаарлалт

- Гэртээ бай. Ажил, сургууль руу, олон нийтийн газраар бүү яв.
- Гэртээ байгаа бусад хүмүүсээс өөрийгөө тусгаарла. Гэртээ байгаа бусад хүмүүсээс аль болох хор тусгай өрөөнд бай. Хүнд өвчний эрсдэлд байдаг хүмүүсээс хол байх нь туйлын чухал.
- Боломжой бол бие засах тусгай өрөө ашигла.
- Хүмүүст хоол бэлдэж, үйлчлэхээс сэргийл.
- Гэртээ хүн битгий ирүүл.
- Нийтийн тээврийн хэрэгсэл, такси зэргээр бүү үйлчлүүл. .

Тархалтаас урьдчилан сэргийл:

- Ханиаж, найтаахдаа амаа тагла. Найтаахдаа хамар амаа салфеткаар таглах буюу, ханцуйгаа ашигла- гараа бүү ашигла- дараа нь ашигласан салфеткаа хогийн саванд хаяад гараа даруй угаа.
- Гараа саван ашиглан хамгийн багадаа хорин секунд орчим байнга угаа- ялангуй ханиаж, найтаах, нусаа нийх, бие засах зэрэг үйлдлүүдийн дараа байнга гараа угаа. Хэрвээ гар чинь анзаарагдахаар бохир байвал ус, савангийн оронд 62%-иас доошгүй спиртен суурьтай гар ариутгагчийг ашиглаж болох юм.
- Гэр доторх эд зүйлсээ дундаа хэрэглэхээс татгалз. Аяга, таваг, халбага, сэрээ, гар нүүрийн алчуур, ор дэрний хэрэгсэл зэргээ гэр бүлийнхэнтэйгээ бүү хувааж хэрэглэ. Эдгээр зүйлсийг хэрэглэсний дараа саван ус ашиглан маш сайн цэвэрлэж угаа. Хиртэй хувцсаа ердийн угаалгын машинд халуун ус, угаалтыг нунтаг ашиглах угаах ба шаардлагатай бол цайруулагч нэмж болно.
- Байнга хүрдэг газруудыг өдөр бүр цэвэрлэж, ариутга. Өдөр бүр хүрдэг гадаргууд ширээний гадаргуу, хаалганы бариул, шүүгээ, ариун цэврийн өрөө, утас, телевизийн удирдлага, түлхүүр, кийборд, ширээ, ширээний хажуу.тал зэрэг ордог. Үүнээс гадна биеэс гарах ялгадас хүрсэн байж болох бүх гадаргууг цэвэрлэж ариутгах ёстой. Гэр ахуйн цэвэрлэгээний шүршигч бодис, салфетка зэргийг зааврын дагуу ашиглах ёстой.

Гэртээ эрүүл мэндээ сахь:

- Амарч, хангалттай шингэн үүж, халуун, өвчнийг багасгахын тулд ацетаминофен(Tylenol®) үү.
 - Эмчийн зөвлөгөө авахгүйгээр 2-оош доош насны хүүхдэд эмчийн бичиггүй эм өгч болохгүйг анхаарна уу.
 - COVID-19-ийг эдгээх, вирусыг гадагшаа тархахаас хамаалах эм байхгүй гэдгийг анхаар
- Хэрвээ шинж тэмдэг хурцадвал, ялангуяа хүнд өвчний өндөр эрсдэлтэй бол эмнэлгийн тусламж хай.
- **Эмнэлгийн тусламж авах ёстой шинж тэмдгүүд :**



- Эмнэлэг, эмчид үзүүлэхээс өмнө болж өгвөл утасдаад COVID-19-өөс болоод тусгаарлалтад байгаагаа хэлвэл эмнэлгийн ажилтнууд бэлдэж, бусдад халдвар тархахаас сэргийлэх юм.
 - Ямар ч хүлээх өрөөнд бүү хүлээ. Амны маск байнга хэрэглэ.
 - Хэрвээ та 911 рүү залгавал COVID-19-өөр тусгаарлагдснаа эмч болон диспетчерт хэлэх ёстой.
 - Олон нийтийн тээврийн хэрэгсэл бүү ашигла.

Нийтийн эрүүл мэндийн ажилтнууд ажилд маань мэдэгдэх үү?

Өөрийн чинь болон бусдын эрүүл мэндийг хамгаалахаас бусад тохиолдолд Нийтийн Эрүүл Мэндийн Газар таны хувийн мэдээллийг ажлын газарт чинь өгч өвчний талаар мэдэгдэхгүй .

Нийтийн эрүүл мэндийн энэхүү чухал асуудалд хамтран ажилласан та бүхэнд талархлаа. .

COVID-19 хүмүүст их хэцүү байж болох тул тодорхой бус байдалд эсгэцийн эрүүл мэндээ зохицуулахад зориулсан зарим хэрэгтэй зөвлөгөөг эндээс авч болно.:

<http://www.acphd.org/media/558462/covid19-managing-emotional-health-20200306.pdf>.

Эрүүл Мэндийн ажилтны тушаалын дэлгэрэнгүй хувилбарыг эндээс авч болно: <http://www.acphd.org/2019-ncov/resources/quarantine-and-isolation>. Хэрвээ танд нэмэлт мэдээлэл шаардлагатай бол www.acphd.org, сайтаар зочлох эсвэл COVID –ийн утас 510-268-2101 залгах буюу ncov@acgov.org- аар мэйл явуулж болно.



COVID-19-ийг ХЯНАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ТУШААЛ #20-05

Нийтийн Эрүүл Мэндийн ТУСГААРЛАЛТЫН Яаралтай Тушаал

Тушаал гаргасан : 2020 оны 4-р сарын 3

Эрүүл Мэндийн Ажилтан бичгэн хэлбэрээр цуцлах хүртэл энэхүү тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

ТУШААЛЫН ТОВЧООН

Калифорния муж улс COVID-19 цар тахлаас болж онц байдал зарлаад байна. Шинэ корона вирус (COVID-19) нь Аламеда дүүргийн хүн ардын эрүүл мэндэд асар их хохирол учруулаад байна. COVID-19 нь ойролцоо байгаа хүмүүсийн нэгээс нөгөө рүү түргэн халдварладаг. Шинжлэх ухааны баримт, өнөөдөр мэдэгдэж байгаа туршлагаас харахад шинэ титэм вирус (COVID-19)-т өртснөөс болж зайлшгүй бус хүнд хэлбэрийн өвчин болон үхлийн эрсдлээс хүн амын эмзэг хэсгийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү тушаалыг гаргаж байна. Аламеда дүүргийн хүн амын нэлээд хэсгийн амь нас, нөхцөл байдал, эрүүл мэнд нь COVID-19-ийн халдвараас болж эрсдэлд орж, улмаар үхэлд хүрэх тохиолдол ч гарч байна. Шинж тэмдэг илрээгүй хүнээс уг вирус бусдад халдварлаж байгаа талаарх баримт нотолгоо улам баталгаажсаар байна. Иймээс COVID-19-ийн халдвар авсан аливаа иргэн илэрч байгаа шинж тэмдгийн түвшнээс (шинж тэмдэггүй, бага зэрэг, хурц), үл хамааран хүн амын эмзэг хэсгийг эрсдэлд оруулж байгаа гэсэн үг.

Өнөөгийн байдлаар COVID-19-ийн эсрэг вакцин болон тусгайлсан эмчилгээ гараагүй байна.

COVID-19-ийн тархалтыг хязгаарлах, эмзэг иргэдийг хамгаалж, Аламеда дүүргийн эрүүл мэндийн тогтоолцоог туйлдуулахаас сэргийлэхийн тулд Аламеда Дүүргийн Нийтийн Эрүүл Мэндийн Газраас халдвар тараах эрсдэлгүй болсныг нь тогтоох хүртэл COVID-19-тэй хүмүүсийг тусгаарлах болон хорио цээрийн дэглэмд хамруулах юм.

КАЛИФОРНИЯ МУЖ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХУУЛИЙН 10140,101085 БОЛОН 120175 –Р ЗҮЙЛҮҮДИЙН ДАГУУ АЛАМЕДА ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНААС ТУШААХ НЬ:

COVID-19 вирустай хэмээн оношлогдсон эсвэл вирусын халдвар авсан байх магадлалтай иргэд өөрсдийгөө тусгаарлах ёстой. Эдгээр хүмүүс энэхүү Тушаалд заасан болон уг Тушаалд эшилсэн Нийтийн Эрүүл Мэндийн зааварчилгааны баримт бичигт дурдсан бүх зааврыг даган мөрдөх ёстой.

Энэхүү тушаалыг зөрчсөн этгээдийг гэмт хэрэг үйлдсэнд тооцох ба 10,000 хүртэлх доллараар торгох буюу нэг жилийн хугацаатай шоронд хорих болно. (Эрүүл мэнд & Аюулгүй Байдлын Хууль §§ 120295 ; Калифорнын Торгуулийн Хуулийн заалт §§ 69 & 148)

COVID-19-өөр халдварласан хэмээн оношлогдсон буюу халдвар авсан байх магадлалтай хүмүүсийг тусгаарлах шаардлага

A. COVID-19-өөр халдварлагсан хэмээн оношлогдсон буюу халдвар авсан байх магадлалтай бүх хүн дараах арга хэмжээг даруй авах шаардлагатай:

1. Өөрсдийгөө гэртээ болон өөр газар тусгаарлах ёстой. Зайлшгүй эмнэлгийн үйлчилгээ авах хэрэгцээнээс бусад тохиолдолд тусгаарласан газраа орхин явах эсвэл бусад олон нийтийн болон хувийг газруудаар явахгүй байх ёстой.
2. <http://www.acphd.org/2019-ncov/resources/quarantine-and-isolation> сайтад тавьсан “Гэрийн Тусгаарлалтын Зааварчилгаа” –д заасан шаардлагуудыг сайтар уншиж, даган мөрдвөл зохино.



3. Ойрын харилцсан хүмүүстээ өөрсдийгөө хорионд байлгах ёстойг нь хэлж сануул. Өөрийгөө хорионд оруулах талаар хэлж сануулах ёстой ойр харилцсан хүмүүс гэдэгт халдвартай хугацаанд тантай хамт байсан хүмүүсийг хэлнэ. Халдвартай үе нь шинж тэмдэг илрэхээс өмнөх 48 цагаас эхэлдэг (эсвэл ямар нэг шинж тэмдэг илрэхгүй бол шинжилгээний хариу эерэг гарсан өдөр) бөгөөд тусгаарлах хугацаа дууссан өдөр хүртэл үргэлжилнэ. (доорх С хэсгийг харна уу). Ойрын харилцаатай хүмүүст:
- Нэг гэрт хамт амьдарсан ЭСВЭЛ
 - Бэлгийн харилцаатай ЭСВЭЛ
 - Маск, өмсгөл, бээлийг өмсөлгүйгээр өөрийг тань арчилж халамжилсан хүмүүс орно.
4. Тэдэнд <http://www.acphd.org/2019-ncov/resources/quarantine-and-isolation>, -д тавигдсан гэр бүлийн гишүүн, ойр дотнын харилцаатай хүн, асран халамжлагчдыг нь COVID-19-ийн халдвар тархахаас сэрэмжлүүлэх талаар бичсэн “Хорио Цээрийн Дэглэмийн Зааварчилгаа”-г уншихыг санал болго. Ойр харилцаатай хүмүүс тань COVID-19-өөр халдварласан байх магадлалтай учир хэдийгээр шинж тэмдэг нь хурц биш боловч бусдад халдвар тараах боломжтойд тооцогддог.

В. COVID- 19-өөр халдварласан иргэд өөрсдийгөө тусгаарлах шаардлагатай.

Энэхүү тодорхойлолт нь дараах хүчин зүйлүүдийг нэг болон түүнээс илүүд хамаарна:

- a) COVID-19-ийг үүсгэдэг SARS-CoV-2A хэмээн нэрлэгдэх вирусын лабораторийн шинжилгээ эерэг гарсан
- b) COVID-19-ийн халдвар авсан эсвэл авсан байх сэжигтэй хүнтэй 14 хоногийн дотор харилцаанд орсон хугацаанд илэрсэн шинж тэмдэг нь COVID-19-ийнхтэй таарах,
- c) COVID-19-ийн халдвар авсан байх магадлалтай талаарх мэдээллийг эмч, эрүүл мэндийн ажилтнаас авсан зэрэг болно.

COVID-19-ийн халдвар авсан болон авсан байх магадлалтай хүмүүс бусдад маш хурдан халдвар тараах боломжтой учраас өөрийгөө тусгаарлах шаардлагатай. Тусгаарлалт нь COVID-19-өөр өвчилсөн хүмүүсийг бусдад халдвар тараахаас сэргийлнэ.

С. Өөрсдийгөө тусгаарласан иргэд тусгаарлалтаа гэртээ хийж энэхүү Тушаалд заасан бүх зааварчилгааг дагаж мөрдөх ба энэ нь дараах үзүүлэлтийг хангаж, COVID-19-ийг тараах эрсдэлгүй болох үе хүртэл үргэлжлэх болно. Үүнд:

- a) Халуун буулгах эм хэрэглэхгүйгээр халуун тогтвортой байх болон ханиалга, амьсгал давхцах байдал намжих зэргээр эдгэрснээс хойш гурав хоног буюу 24 цагаас багагүй хугацаа өнгөрөх **БА**
- b) Шинж тэмдэг эхэлснээс хойш 10-оос багагүй хоног өнгөрсөн байх .
- c) Шинжилгээгээр эерэг гарсан боловч шинж тэмдэг огт илрээгүй хүмүүс шинжилгээ өгснөөсөө хойш 10 хоногийн хугацаанд тусгаарлагдсан байх.

Ард нийтийн эрүүл мэндийг хамгаалахын тулд энэхүү тушаалыг биелүүлэх ёстой этгээдүүд тушаалыг зөрчсөн тохиолдолд албадан саатуулах, эмнэлгийн байр эсвэл өөр бусад байранд байрлахыг шаардах зэрэг нэмэлт арга хэмжээ авах эрхийг Эрүүл мэндийн ажилтан эдэлнэ. Энэхүү тушаалыг зөрчих нь шоронд орох, торгуулах, эсвэл хоёр арга хэмжээг зэрэг авахуулах гэмт хэрэг үйлдсэнд тооцогдоно.

ТУШААЛ ГАРГАСАН:

Аламеда Дүүргийн Эрүүл Мэндийн Ажилтан
Доктор Эрика Пэн

2020 оны 4-р сарын 3

Огноо



COVID-19-ийг ХЯНАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ТУШААЛ #20-06

Нийтийн Эрүүл Мэндийн **ХОРИО ЦЭЭРИЙН**

ДЭГЛЭМИЙН Яаралтай Тушаал

Тушаал гаргасан : 2020 оны 4-р сарын 3

Эрүүл Мэндийн Ажилтан бичгэн хэлбэрээр цуцлах хүртэл энэхүү тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

ТУШААЛЫН ТОВЧООН

Калифорниа муж улс COVID-19 цар тахлаас болж онц байдал зарлаад байна. Шинэ корона вирус (COVID-19) нь Аламеда дүүргийн хүн ардын эрүүл мэндэд асар их хохирол учруулаад байна.. COVID-19 нь ойролцоо байгаа хүнээс хүн рүү түргэн халдварладаг. Шинжлэх ухааны баримт, өнөөдөр мэдэгдэж байгаа туршлагад тулгуурлан харахад шинэ корона вирус (COVID-19)-т өртснөөс болж тойрч болох хүнд хэлбэрийн өвчин болон үхлийн эрсдлээс хүн амын эмзэг хэсгийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү тушаалыг гаргаж байна. Аламеда дүүргийн хүн амын нэлээд хэсгийн нас, нөхцөл байдал, эрүүл мэнд нь COVID-19-ийн халдвараас болж эрсдэлд орж, улмаар үхэлд хүрэх тохиолдол ч гарч байна. Шинж тэмдэг илрээгүй хүнээс уг вирус бусдад халдварлаж байгаа талаарх баримт нотолгоо улам баталгаажсаар байна. Иймээс COVID-19-ийн халдвар авсан аливаа иргэн илэрч байгаа шинж тэмдгийн түвшнээс (шинж тэмдэггүй, бага зэрэг, хурц), үл хамааран хүн амын эмзэг хэсгийг эрсдэлд оруулж байгаа юм.

Өнөөгийн байдлаар COVID-19-ийн эсрэг вакцин болон тусгайлсан эмчилгээ гараагүй байна.

COVID-19-ийн тархалтыг хязгаарлах, эмзэг иргэдийг хамгаалж, Аламеда дүүргийн эрүүл мэндийн тогтоолцоог туйлдуулахаас сэргийлэхийн тулд Аламеда Дүүргийн Нийтийн Эрүүл Мэндийн Газраас халдвар тараах эрсдэлгүй болсныг нь тогтоох хүртэл COVID-19-тэй хүмүүсийг хорио цээрийн дэглэмд хамруулан бусдаас тусгаарлах юм.

КАЛИФОРНИА МУЖ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХУУЛИЙН 10140,101085 БОЛОН 120175 –Р ЗҮЙЛҮҮДИЙН ДАГУУ АЛАМЕДА ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНААС ТУШААХ НЬ:

COVID-19-тэй хүний гэр бүлийн бүх гишүүн, ойрын харилцаатай хүмүүс болон асран халамжилагчид өөрсдийгөө хорио цээрийн дэглэмд оруулах ёстой. Эдгээр хүмүүс энэхүү Тушаалд заасан болон уг Тушаалд эшилсэн Нийтийн Эрүүл Мэндийн зааварчилгааны баримт бичигт дурдсан бүх зааврыг даган мөрдөх ёстой.

Энэхүү тушаалыг зөрчсөн этгээдийг гэмт хэрэг үйлдсэнд тооцох бөгөөд 10,000 хүртэлх доллараар торгох буюу нэг жилийн хугацаатай шоронд хорих болно. (Эрүүл мэнд & Аюулгүй Байдлын Хууль §§ 120295 ; Калифорнийн Торгуулийн Хуулийн заалт §§ 69 & 148)



COVID-19-тэй иргэний гэр бүлийн гишүүд, ойрын харилцаатай хүмүүс болон асран хамгаалагчдын хорио цээрийн дэглэмийн шаардлага

COVID-19-тэй хүмүүстэй ойрын харилцаатай байсан хүмүүсийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Халдвар тээгчтэй хамт амьдарч байсан эсвэл нэг дор хамт байсан ЭСВЭЛ
- Халдвар тээгчийн бэлгийн хавьтагч байх ЭСВЭЛ
- Маск, зориулалтын хувцас болон бээлийгүйгээр халдвар тээгчийг асарсан

БОЛОН

Халдвартай болсон нь тогтоогдсноос хойш харилцаатай байсан хүмүүс орно. Мөн шинж тэмдэг илэрч эхлэхээс өмнө 48 цагийн дотор халдвар авсан болон тусгаарлалтаас гарах хүртэлх хугацаанд байгаа этгээд орно.

COVID-19-ийн халдвар авсан нь тогтоосон бүх иргэдтэй ойрын харилцаатай байсан хүмүүс дараах арга хэмжээг даруй авах ёстой. Үүнд:

1. COVID-19-ийн халдвар авсан болон авсан байх магадлалтай хүмүүстэй харилцсан сүүлийн өдрөөсөө эхлэн 14 хоногийн хугацаанд өөрийнхөө гэр болон өөр газраас гарахгүй бай. COVID-19 авах болон тараах өндөр эрсдэлтэйд тооцогдох учир эдгээр хүмүүс 14 хоногийн хорио цээрийн хугацаанд бүхлээр нь өөрсдийгөө хорио цээрийн дэглэмд хамруулах шаардлагатай.
2. Хорио цээрийн дэглэмд хамрагдсан хүмүүс зайлшгүй шаардлагатай эмнэлгийн тусламж авахаас бусдаар байгаа газраасаа гарах, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зэрэг үйлдэл гаргаж үл болно.
3. <http://www.acphd.org/2019-ncov/resources/quarantine-and-isolation> сайтад тавьсан “Хорио Цээрийн Зааварчилгаа” –д заасаан шаардлагуудыг сайтар уншиж, даган мөрдвөл зохино.
4. Хэрвээ хорио цээрийн дэглэм мөрдөж байгаа иргэнд өвчлөх, халуурах, ханиах, амьсгал давчдах зэрэг шинж тэмдэг илэрвэл (шинж тэмдэг хөнгөн ч гэсэн), тэд гэртээ өөрсдийгөө тусгаарлаж, бусдаад зай барьж <http://www.acphd.org/2019-ncov/resources/quarantine-and-isolation>-д тавьсан “Гэртээ Тусгаарлах” зааварчилгааг сахин мөрдөх ёстой. Учир нь эдгээр хүмүүс COVID-19-ийн халдвар авсан байх магадлалтай бөгөөд ийм тохиолдолд эмзэг иргэдэд халдвар тарааж болох юм.

Ард олны эрүүл мэндийг хамгаалахын тулд энэхүү тушаалыг биелүүлэх ёстой этгээдүүд тушаалыг зөрчсөн тохиолдолд тэднийг албадан саатуулах, эмнэлгийн байр эсвэл өөр бусад байранд байрлахыг шаардах зэрэг нэмэлт арга хэмжээ авах эрхийг Эрүүл мэндийн ажилтан эдэлнэ. Энэхүү тушаалыг зөрчих нь шоронд орох, торгуулах, эсвэл хоёр арга хэмжээг зэрэг авахуулах гэмт хэрэг үйлдсэнд тооцогдоно.

ТУШААЛ ГАРГАСАН :

Аламеда Дүүргийн Эрүүл Мэндийн Ажилтан
Доктор Эрика Пэн

2020 оны 4-р сарын 3

Огноо